

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 08 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн 15 цаг 30 минутад эхэлж, мөн өдрийн 20 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 4 цаг 40 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Баяр наадам зохион байгуулах хороо байгуулах тухай	Баяр наадам зохион байгуулах хороо байгуулах тухай хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
2	Ардын хувьсгалын 100 жил, аймгийн 90 жилийн ойн бүтээлч ажлын төлөвлөгөө хэлэлцүүлэх тухай	Ардын хувьсгалын 100 жил, аймгийн 90 жилийн ойн бүтээлч ажлын төлөвлөгөө хэлэлцүүлэх тухай явцад гарсан саналыг тусгаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх үүрэг болгов.
3	“Стандарттай Ховд” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хэлэлцүүлэх тухай	“Стандарттай Ховд” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хэлэлцүүлэх явцад гарсан саналыг тусгаж 10 хоногийн дараа дахин аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга Б.Гомбосүрэнд үүрэг болгов.
4	Зарим газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай	Манхан сумын газрыг Ишгэн толгой бол түүхэн дурсгалт газар, жи-мобайлын антен байдаг учир наашлуулж олон улсын босоо тэнхлэгийн зам хэвтээ тэнхлэгийн Улаанбаатар хотыг холбосон 3 замын уулзварт одоо цайны газар, буурчын газар үйл ажиллагаа явуулж байгаатай ойролцоо нэг газар төвлөрүүлэх, Булган сумын газар улсын тусгай хамгаалалттай хилийн зурваст орж байна. Ийм учраас дахин судлаж танилцуулахаар хойшлуулав.
5	Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга хэлэлцүүлэх тухай	“Консалтинг”ХХК-нийг дуудан ирүүлж уулзаж эсвэл цахим хурал хийж шийдвэрт хүрч байж дараа нь тендер зарлаж төлөвлөлт хийхийг аймгийн

		Засаг даргын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого хариуцсан орлогч Т.Жаргалсайхан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх нарт үүрэг болгов.
--	--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР